



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Ажил хүлээн авах комисс
томилох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Иргэний хуулийн 351 дүгээр зүйлийн 351.1.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа “Жаргалант” амралтын газрын гэрүүдийн засвар, орчны тохижилт, шинэчлэлийн ажлын /Багц-2/ ИНЕГ/ЦА/ТББ/А-06/17 дугаар гэрээт ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга:	Ж.Амарсүрэн	Сэргээн засах амралтын дарга
Гишүүд:	Д.Эрдэнэцогт	Аж ахуйн тасгийн менежер
	Ж.Билэгсайхан	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын ашиглалтын өмнөх захиргааны албаны барилгын хяналтын инженер
	Д.Цэцэгбаяр	Сэргээн засах амралтын ахлах нягтлан бодогч
	Д.Жамъянхорол	Сэргээн засах амралтын аж ахуйн дарга
	С.Тамир	Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч

2. Дээрх ажлыг гэрээнд заасан ажлын тоо хэмжээ, бусад заагдсан шаардлагуудын дагуу шалгаж хүлээн авах, комиссын акт, холбогдох бусад материалыг бүрдүүлж, Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлэхийг Комиссын дарга /Ж.Амарсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН